



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 67

Мандалговь

┌ Хөрөнгө акталж, данснаас хасах ┐  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3,619,375 /гурван сая зургаан зуун арван есөн мянга гурван зуун далан тав/ төгрөгийн балансын үнэтэй, 3,091,550 /гурван сая ерэн нэгэн мянга таван зуун тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурдсан складан чулуун барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасгай.

- 2.1 Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
- 2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах.
- 2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх
- 2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дүгээр сарын  
28-ний өдрийн 67 тогтоолын хавсралт

**Гурвансайхан сумын ЗДТГазрын складан чулуун барилгыг акталж, данснаас хасах барилгын мэдээлэл**

| №               | Барилга,<br>байгууламжийн<br>нэр | зориулалт | Хэмжих нэгж    |                | Ашиглалтад<br>орсон огноо | Ашиглалтын<br>нийт хугацаа<br>/жилээр/ | Балансын үнэ  | Хуримтлагдса<br>н элэгдэл  | Үлдэгдэл өртөг   |
|-----------------|----------------------------------|-----------|----------------|----------------|---------------------------|--|---|--|--|
|                 |                                  |           | Хэмжих<br>нэгж | Биет<br>хэмжээ |                           |  |   |  |  |
| 1               | Склад                            | Агуулах   | м2             | 267.3          | 1963.01.01                | 7                                      | 3,619,375.65  | 527,825.62   | 3,091,550.03   |
| <b>Нийт дүн</b> |                                  |           |                |                |                           |  |   |  |  |
|                 |                                  |           |                |                |                           |  | <b>3,619,375 /гурван сая зургаан зуун арван есөн мянга гурван зуун далан тав жаран таван мөнгө/</b> | <b>527,825.62 /Таван зуун хорин долоон мянга найман зуун хорин тав жаран хоёр мянга/</b> | <b>3,091,550.03 /гурван сая ерэн нэгэн мянга таван зуун тавь гурван мөнгө/</b> |